



Г

СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Г

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 71 99  
Цахим хуудас: [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn)

2024.11.08 № 03/6362

танай -ны № -т

### Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зарласан ЗТХЯ/20210101127 дугаартай Шинэ тойрог авто зам төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) тендер шалгаруулалтад сонирхогч этгээдүүдээс ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

| № | Тодруулга  | Тодруулгын хариу   |
|---|--|--|
| 1 | Тендерийн баримт бичгийн ТШЗ 20.1 -д заагдсан Маягт 5 ба Маягт 6 г бөглөхөд шаардлагатай Гэрээ баталгаажуулах маягт хэсгийн гэрээний "Хавсралт 6" ба "Хавсралт 4" –ийг оруулж өгнө үү.   | Маягтыг хавсралтаар оруулав.   |
| 2 | "Шинэ тойрог авто зам" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар) тендерийн баримт бичигт хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд бүх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ гэж заасан.<br>"Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц"-д Монгол улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай хууль 2008 оны 12 сарын 25 ны өдөр батлагдсан.<br>Ямар баримт бичгүүд албан ёсны баримт бичигт хамаарах талаар.<br>Гадаад улсын төрийн байгууллагаас олгогдсон гэрчилгээ, тодорхойлолтууд, их дээд сургуулиудын диплом, мэргэжлийн сертификатууд албан ёсны баримт бичигт хамаарах эсэх талаар.<br>Гадаад хэл дээрх баримт, материалуудыг гадаад улс дахь Монгол улсын элчин сайдын консулын газраар баталгаажуулан Монгол улсад хүлээн авч орчуулга хийлгэн тендерийн материалд оруулж болох эсэх талаар тодруулж өгнө үү. | Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгүүдийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ. Гадаад улсын төрийн байгууллагаас олгогдсон гэрчилгээ, тодорхойлолтууд, их дээд сургуулиудын диплом, мэргэжлийн сертификатууд хамаарна. |

1110205976

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.дахь хэсэгт заасны дагуу цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

ДАРГА



П.ХАДБААТАР

ХАВСРАЛТ 4

АЖЫН ХӨТӨЛБӨР АЖЫН ХУВААРЫН

(Гендерт оролцогч энэхүү хавсралтад дурдсан мэдээллийг тендерийн баримт бичигт санаалаар ирүүлэх бөгөөд гэрээндийн хэлэлцээрийн шатанд эцэслэн тохирно)

ХАБСРАД 6

АЖЛЫН АРГАЧЛАЛ

(Тэндэргүй оролцогч энэхүү хавсралтад дурдсан мэдээллийг тендерийн баримт бичигт санаалаар ирүүлэх бөгөөд гэрээнд хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиран)

|   |        |     |   |      |                |         |                           |
|---|--------|-----|---|------|----------------|---------|---------------------------|
| № | Үе шат | Нэр | № | Товч | Ажил үйлчилгээ | Тайлбар | Ажлын аргачлал<br>тайлбар |
|   |        |     |   |      |                |         |                           |